



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 389

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн
төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнийг томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 2.10, 4.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 01/3382 дугаартай албан бичгээр ирүүлсэн санал, Авлигатай тэмцэх газрын 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 05/10805 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг тус тус харгалзан “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнээр Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Мяндасмааг 2022 оны 9 дүгээр сарын 19-ний өдрөөс томилсугай.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132002810